



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№35 /249/

2022.02.21

Цаг үе, үйл явдал

ЦЭРГИЙН ЦАГДААГИЙН БҮРЭЛДЭХҮҮН ЧУУЛЖ БАЙНА



ЗХЖШ-ын даргын тушаалаар Цэргийн хүрээ, хотонд цэргийн цагдаагийн бүрэлдэхүүнтэй явуулах сургалтыг энэ сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулж байна.

Сургалтад ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтэс, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн удирдлага, тус ангийн Цэргийн цагдаагийн рот, салааны захирагч нар, зарим бүрэлдэхүүн болон Улаанбаатар цэргийн хотхоны Цэргийн цагдаагийн тасгийн бие бүрэлдэхүүн оролцож байна. Мөн цахимаар хөдөө, орон нутгийн цэргийн хүрээний Цэргийн цагдаагийн тасгийн бие бүрэлдэхүүн оролцож байгаа нь энэ удаагийн сургалтын нэг онцлог ажээ.

Уг сургалтыг нээж ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба үг хэлсэн юм. Тэр бээр хэлсэн үгэндээ ЗХЖШ-ын

даргын тушаалын дагуу шинээр томилогдсон Цэргийн цагдаагийн рот, цэргийн хүрээ, хотхоны Цэргийн цагдаагийн тасгийн бие бүрэлдэхүүн та бүхэн Зэвсэгт хүчний хэмжээнд дэвшүүлж буй зорилго, зорилтуудыг ханган биелүүлэх, нэн ялангуяа цэргийн хүрээ, хотонд "Цэргийн цагдаагийн ажиллагааны журам"-ын хэрэгжилтийг сайтар зохион байгуулж, сахилга, дэг журмыг бэхжүүлэхэд онцгой анхаарч ажиллах шаардлагатай. Цэргийн албаны хэлтэс, Цэргийн цагдаагийн рот, тасаг нь эрх зүйн хүрээнд, бодлогын түвшинд шинээр байгуулагдаж, үйл ажиллагааг явуулж буй хэдий ч харьцангуй идэвх зүтгэл, бүтээлч санаачилгатай ажиллаж буй хэмээн үнэлж байгаа. Та бүхэн хууль тогтоомж, удирдлагын баримт бичгүүдийг

сайтар судлан мэргэжлийн үр чадвар, хэлний мэдлэг, бие бялдар, сэтгэл зүйн өндөр бэлтгэлтэй байж, бусдыг ямагт манлайлж явах ёстой. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа эрсдэлийг сайн тооцож, аюулгүй байдлыг сайтар хангаж, хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг чанд сахиж ажиллах, цаашид өөрсдийгөө байнга хөгжүүлж, дараагийн албан тушаалд дадлагажиж байх хэрэгтэй. Та бүхний өмнө тулгамдаж буй асуудлыг шат дараатайгаар шийдвэрлэхэд бид бүхэн анхаарал хандуулж ажиллах болно" гэж онцоллоо.

Энэхүү сургалтын явцад "Цэргийн цагдаагийн үйл ажиллагаа, цаашидын чиг хандлага", "ОХУ, БНТУ, ХБНГУ-ын Цэргийн цагдаагийн чиг үүрэг, зэвсэг, техник, бүтэц, зохион байгуулалт", "Зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаа", "Эрүүгийн

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хойшлуулшгүй ажиллагаа" зэрэг сэдвийг хөндөж, харилцан санал солилцоно.

Мөн "ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтсээс дэвшүүлж буй зорилго, зорилтууд, тэдгээрийг хангах нь", ЗХЖШ-ын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга, дэг журмыг бэхжүүлэх зөвлөл"-өөс 2022 онд дэвшүүлсэн зорилго, зорилтууд, түүнийг хангахад Цэргийн цагдаагийн нэгжүүдийн үүрэг", "Нэгтгэл, анги, байгууллагын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга, дэг журмыг бэхжүүлэх салбар зөвлөл-ийн ажлыг Цэргийн цагдаагийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах, зохион байгуулах" зэрэг асуудлыг хөндөхөөр төлөвлөдөг байна.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

Түүхэнд энэ өдөр

1921 он

Хяран харуулын Цагаан бургас хэмээх газарт Ардын намын цэргийн анхны хороог Д.Сүхбаатар удирдан зохион байгуулж, даргаар нь Б.Пунцагш цэргийн ламаар Ц.Хасбаатар, пулемёт бууны даргаар Дамдинсүрэн нарыг тус тус томилжээ.

1936 он.

МАХЦ-ийн даргалах бүрэлдэхүүнд алдар цол олгох болж, тэдний алба хаах дүрмийг баталжээ. "Улсын өрлөг жанжин /Маршал/" хэмээх цэргийн дээд алдар цолыг анх удаа Г.Дэмид, Х.Чойбалсан нар олгожээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-12	-30

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
32	22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,861.00	2,864.0
EUR	3,240.0	3,255.0
CNY	450.00	451.00
RUB	37.40	38.20
JPY	24.73	24.85
KRW	2.40	2.41

ЗУРХАЙ



2022.02.21 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 20/

ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР БАР САРЫНТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Өлсөж ундаасна
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.48-18.23
Барилдлага:
Үл зохилдох
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
САНСАР
Суудал: Шороо

Энэ өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээхэд муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ДОРНЫН ЗУРХАЙ:
Энэ өдөр үхэр, тахиа жилтнээ ЗЕРЭГ сайн



Монгол цэрэг энхийн үйлсэд

МОНГОЛ ГЕНЕРАЛД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улс дахь НҮБ-ын энхийг сахиулах "UNMISS" ажиллагааны Жуба секторын командлагч, тус ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний Үндэсний ахлах төлөөлөгч бригадын генерал Б.Эрдэнэбат

үүрэгт ажлаа амжилттай дуусгалаа. Үүнтэй холбогдуулан БНХАУ, Руанда, Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улс, Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Этиоп Улсуудын Хүндэт харуул 2022 оны 2 дугаар сарын

15-ны өдөр жагсан хүлээн авч хүндэтгэл үзүүлэн үдэн гаргалаа. Бригадын генерал Б.Эрдэнэбат 4300 гаруй энхийг сахиулагчтай тус секторын командлагчаар жил гаруйн хугацаанд үүргээ амжилттай гүйцэтгэсэн юм. Ташрамд дурдахад тэрээр Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад НҮБ-ын цэргийн ажиглагч, батальон захирагч, секторын штабын дарга, секторын командлагчаар нийт дөрвөн

удаа энхийг сахиулагчаар үүрэг гүйцэтгэжээ.

Тус ёслолын арга хэмжээнд Жуба секторын штаб, цэргийн багуудын удирдлагууд болон Монгол Улсын Зэвсэгт хүчнээс үүрэг гүйцэтгэж буй штабын офицер, ахлагч, цэргийн багийн төлөөлөл оролцлоо. Ёслолын арга хэмжээний төгсгөлд дурсгалын зураг авахуулж, гэрчилгээ гардууллаа.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,270,897 /69.8%/	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,172,253 /66.8%/	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,018,527 31,0% 92,163 /3,0%/
НИЙТ БАТЛАГДСАН 8199 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 55	ЭДГЭРСЭН 8025

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 416,057,035
Эдгэрсэн Нийт: 338,806,009
Нас барсан Нийт: 5,857,018



Цахим шууданд

“МӨСНИЙ БУУХИА” ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Б.Батбаяр нар шалгарлаа. Энэхүү арга хэмжээ нь бие бүрэлдэхүүнийг хөдөлгөөний дутагдлаас сэргийлж, эрч хүчээр сэлбэхийн зэрэгцээ хамт олны уур амьсгалыг нэгтгэсэн үр дүнтэй арга хэмжээ боллоо. Тэмцээний төгсгөлд алба, салбар сурталчлах аяны тугийг Хөвүүр гүүрний ротын хамт олонд гардуулан өгөн юм. Түүнчлэн Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн хүрээнд “Энхийг сахиулах ажиллагаанд Монгол эмэгтэйчүүдийн оролцоо” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн ахлагч Б.Уянга илтгэл тавьлаа. Тус арга хэмжээнд энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэргийн алба хаагчдын гэр бүлийг урьж хүндэтгэл үзүүлсэний зэрэгцээ ангийн үйл ажиллагаатай танилцуулж, энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын видео бичлэгийг үзүүлээ.

Дэслэгч Ч.ОЮУНЧИМЭГ

Зэвсэгт хүчний 234 дүгээр анги
Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сэтгэл зүйн хангалтын төлөвлөгөөний дагуу алба, салбар сурталчлах аяныг Захиргааны удирдлага, сургалт, соёл хүмүүжлийн албанаас бие бүрэлдэхүүний дархлааг дэмжих, эрүүл амьдралын зөв дадал зуршлыг бий болгох зорилгоор “Эрүүл агаар-Эм” уриатай “Мөсний буухиа” тэмцээнийг зохион байгууллаа.

байрт, Хөвүүр гүүрний ротын “Галзуу барууд” баг дэд байрт тус тус шалгарлаа. Мөн удирдлагуудын дунд “300 метрийн зайг тэшүүрээр хэн хамгийн бага хугацаанд туулах вэ” хөгжөөнт буухиа тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд тэргүүн байрт ангийн ахлагч, тэргүүн ахлагч Г.Мягмарсүрэн, дэд байрт захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа

Арга хэмжээний хүрээнд салбарууд тэшүүртэй 100 метр туулах, чаргаар 50 метрт чирэх, гарын хүч ашиглан чаргаар гулгах зэрэг 4 цэгийг туулан хурд хүч, авьяас чадвар, авхаалж самбаагаараа бусдыгаа манлайлсан Хөвүүр гүүрний ротын цэргийн гэрээт алба хаагчдын баг тэргүүн



СУРГАЛТ, ДАДЛАГААР ҮҮРГЭЭ АМЖИЛТТАЙ ГҮЙЦЭТГЭЛЭЭ

Зэвсэгт хүчний 336 дугаар анги

Байлдааны гавьяаны улаан тугийн одонт, жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Зэвсэгт хүчний 336 дугаар анги 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу 30 километрийн явган марш, салааны хоногийн сургууль, салааны байлдааны буудлагыг энэ сарын 16-

17-ны өдрүүдэд амжилттай зохион явууллаа.

Энэхүү цэргийн сургалт бэлтгэл нь ангийн офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийн бүрэлдэхүүнтэй өвлийн улиралд хэт хүйтнийг тэсвэрлэн гарах буюу цагийн байдлын хүндрүүлсэн нөхцөлд үүрэг гүйцэтгэхэд сурган дадлагажуулснаараа онцлог юм.

Бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах, албан тушаалд нь сурган дадлагажуулах, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшнийг дээшлүүлэх зорилгоор явагдсан тус хээрийн сургуулиар алба хаагчид өмнөө тавигдсан үүргийг амжилттай гүйцэтгэж чадсан юм.

Ахлах дэслэгч А.АЛТАНХУЯГ



ОРОН НУТГИЙН ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНД ТЭРГҮҮЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 186 дугаар анги
Орхон аймгийн ЗДТГ-аас санаачлан хэрэгжүүлж “Өвлийн спортыг

хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд тус аймаг дахь төрийн цэргийн байгууллагуудын дунд “Эрдэнэт мөнгөн

өвөл-2022” цогцолбор тэмцээн явагдлаа.

Энэхүү тэмцээнд Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн алба хаагчид амжилттай оролцсон бөгөөд биатлоны төрөлд эмэгтэй баг тамирчид тэргүүн, эрэгтэй баг тамирчид дэд байрт шалгарч, багийн дүнгээр “Шилжин явах цом”-ын эзэд болов. Спортлог байдлаараа анги, хамт олноо орон нутагтаа сурталчилсан баг тамирчдад ангийн захирагч, хурандаа Д.Жигжидсүрэн баяр хүргэж, албанд нь өндөр амжилт хүслээ.

Ахмад Э.АРИУНТУЯА



ГОВИЙН БҮСИЙН СУРГАЛТЫН ТӨВИЙН РАЙОНД АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ



Зэвсэгт хүчний 167 дугаар анги
2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу

ангийнхаа Говийн бүсийн сургалтын төвийн районд энэ сарын 18-ны өдөр тасаг, тоотын байлдааны буудлагыг амжилттай зохион байгуулж

явууллаа.

Энэ үеэр хугацаат цэргийн алба хаагчдынхаа цэргийн хэргийн мэдлэг, дадлага, чадварыг нэмэгдүүлэх, зэвсэг, техниктэй харьцах дадлага, чадварыг дээшлүүлэх, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах зорилгоор сургалт, дадлагыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан юм. Мөн бие бүрэлдэхүүнтэй мэдээлэл, сурталчилгаа, сэтгэл зүйн хангалтын ажлыг сургалтын үе шаттай хослуулан явуулж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах болон цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

